



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 26

№ 01/20 АУА-2018/25/СТА-743 Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **1,081,546.00** /нэг сая наян нэгэн мянга таван зуун дөчин зургаан/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Хүнсний материалыг батлагдсан орц нормын дагуу бодож олгоогүй нийт **956,176.00** төгрөгийн хүнсний материал илүү зарцуулсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 4 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар батлагдсан /Цэцэрлэг сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм"-д тогтоосон нормативыг баримтлаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*/ гэж заасныг зөрчсөн.

2. Ажил олгогчоос төлөх **125,370.00** төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн цалингийн зардлаас зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын /*Үндсэн цалин-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана*/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /*Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй*/, 4.1.7-д /*Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*/, 4.1.3-д /*Төсвийн хөрөнгийг үр ашиггүй,*

зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл залтыг зөрчсөн гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалт хийх;
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн шууд захирагч Б.Оюунтөгс, нягтлан бодогч Д.Мөнхдорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:


АУДИТОР



Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ



Б.ОЮУНТӨГС

НЯГТЛАН БОДОГЧ

Д.БИЛЭГСАЙХАН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.